



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.20 № 296
танай _____-ны № _____-т

ХОТЫН СТАНДАРТ ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт
зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 19. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.20 № 297
танай _____-ны № _____-т

ХОТЫН СТАНДАРТ ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.МӨНХ-ОЧИР



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/644/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Ц.Бат-Өлзий

Утас: 327734 Цахим хаяг: bat-ulziits@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр

Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Н.Баттогоо

Утас: 325093 Цахим хаяг: battagoon@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	4
2.Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.Менежментийн захидал	10
Эрсдэл:.....	10
Өгсөн зөвлөмж:.....	10
Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	11
Эрсдэл:.....	12
Өгсөн зөвлөмж:.....	12
Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
Эрсдэл:.....	12
Өгсөн зөвлөмж:.....	12
Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
Эрсдэл:.....	13
Өгсөн зөвлөмж:.....	13
Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь

- ❖ *Хүн төвтэй хот.* Ёс зүй, үнэт зүйлтэй, соёлжсон хотын иргэнийг хөгжүүлж төлөвшүүлнэ;
- ❖ *Орчин төвтэй хот.* Иргэндээ ээлтэй, эрсдэлгүй ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлнэ.
- ❖ *Төлөвлөлт төвтэй хот.* Шинжлэх ухаан, эдийн засгийн тооцоо судалгаатай ухаалаг технологийн шийдэлд тулгуурласан, олон улсад мөрдөгдөж байгаа стандартыг нэвтрүүлж, тогтвортой хөгжил бүхий хот болно.

Тус газар нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотын цаашдын хөгжлийг хангах тогтвортой хөгжлийн зорилтыг биелүүлж, иргэдийн амьдрах орчны ая тух, аюулгүй байдлыг хангасан хот болон хөгжихөд хотын стандартын баримт бичгийг боловсруулж, олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж ажиллах чиг үүрэг тавин ажиллажээ.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрыг Монгол Улсын Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 100 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019.03.22-ны өдрийн А/241 дүгээр захирамжаар 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд 2019 онд шинээр байгуулагдсан байгууллага тул суурь үзүүлэлтийг энэ оны батлагдсан төсвийн дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн нийт 447,286.0 мянган төгрөгөөс тооцон 8,946.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 7,429.6 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн төсвөөс 17 хувиар бууруулж тайлагнасанатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн 110,593.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		535.57	535.57
Урьдчилгаа	0	-	-
Бараа материал		7,293.68	7,293.68
Үндсэн хөрөнгө		102,764.37	102,764.37
Нийт хөрөнгө		110,593.62	110,593.62
Өр төлбөр	0	503.52	503.52

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Төмөрдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 2 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, НТАГ-ын ахлах аудитор Н.Баттогоо хариуцаж хэрэгжүүлэв.

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2020 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн 01/20 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0	110,090.11	110,090.11
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0	110,593.62	110,593.62

Авлага, өглөг үүссэн шалтгаан нь ажиллагсдын НДШ-ийг илүү дутуу суутгасантай холбоотой, тооцоог актаар баталгаажуулан тайлагнасан байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 102,764.4 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд бүтцийн өөрчлөлтөөр шинээр зохион байгуулагдсантай холбоотой 104,546.4 мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн, хуримтлагдсан элэгдэл 1,782.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,293.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бичиг хэргийн материал, аж ахуйн материалын үлдэгдэлтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 110,593.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд ТШЗ-ийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан нийт 447,286.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 286,184.5 мянган төгрөг буюу 64.0 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшуулал зардал 142,258.2 мянга, НДШ-ийн зардал 17,989.0 мянга, бусад зардал 854.3 мянга нийт 161,101.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсөв: НЗД-ын А/1162-р захирамжаар арга хэмжээний зардалд 33,888.0 мянган төгрөг өгснийг тус зардалд бүрэн зарцуулснаар тайлагнажээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл илрээгүй 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33,091.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 27,852.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,973.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,266.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

- Ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан 851.0 мянган төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг зөрчиж, аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг;

- Тушаал шийдвэргүй, нотлох баримтгүй ажиллагсдын гэр бүлийнхэнд 1,122.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчиж, аудитын үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй материаллаг эрсдэлтэй асуудал гараагүй болно

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 24 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2019 онд шинээр байгуулагдсан тул өмнөх онд аудит хийгдээгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг. Бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2. "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудыг зөрчсөн.

Эрсдэл:

- Хууль тогтоомжууд зөрчигдөж, татварыг нуун дарагдуулах боломжийг бусдад олгоно.
- Татварын орлого дутуу бүрдэх;

Өгсөн зөвлөмж:

- Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх;

- Цаг тухайд цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Жилийн эцсийн тооллогын бүртгэлийн дүнг НББ-ийн программ, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 290.0 мянган төгрөгийн ШТМ-ын талоны үлдэгдэлд тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2. *“Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.”* заалт, 67.1 *“Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.”* заалтуудыг зөрчсөн.

Эрсдэл:

- Хөрөнгө алга болох, шамшигдах;
- Хөрөнгийн зарцуулалтад тавигдах дотоод хяналт алдагдах;
- Заавар журам зөрчигдөж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт суларна;

Өгсөн зөвлөмж:

- Жилийн эцэст бараа материалын үлдэгдэлд тооллого хийж, тооллогын үлдэгдлийг нягтлан бодогч тулгаж тооцоо бодох, илүү дутуу зөрүүг шийдвэрлэх, НББ-ээр тавих хяналтыг сайжруулах;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ын зүгээс хойшид анхаарч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,486.0 мянган төгрөгийн баримтаар бүртгэл хөтөлж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. *Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.* гэсэн заалтыг зөрчсөн.

Эрсдэл:

- Хөрөнгө шамшигдах, алга болох;
- Хөрөнгө буруу илэрхийлэгдэх;
- Заавар журам зөрчигдөж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт суларна;

Өгсөн зөвлөмж:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэхгүй байх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;
- Албан тушаалтан тушаал шийдвэрээр цаг тухай бүрд гаргаж байх;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Дуудлагаар автомашин унадаг албан тушаалтнуудаас шалтгаалан илүү цагийн хөлс төлсөн, өртөг өндөртэй шатахуун авч зарцуулсан, нэрийн хуудас хэвлүүлсэн зэрэг 356.4 мянган төгрөгийн үрэлгэн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчиж, аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Эрсдэл:

- Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах;
- Заавар журам зөрчигдөж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт суларна;

Өгсөн зөвлөмж:

- Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

5. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

- Шатах тослох материалыг 133.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсан /Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос илүү зарцуулсан/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Сангийн сайдын 2006.11.27-ны өдрийн 388 тоот тушаалын 1 хавсралтын 3 бүлэг "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсгийн 3.2 дахь заалт "... гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч

бүртгэнэ" заалтыг зөрчиж, аудитын үнэн зөв, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй.

Эрсдэл:

- Зардал буруу илэрхийлэгдэх;
- Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах;

Өгсөн зөвлөмж:

- Автомашины жишиг нормыг үндэслэн шатахуун зарцуулалтын тооцоог үнэн зөв бодож данс бүртгэлд тусгах;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга
Бөгөөд аудитын менежер

Ц.Бат-Өлзий

Аудитын менежер

Д.Отгонбаяр

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Н.Баттоогоо



Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Хангарди ордон, Ц.Жигжиржавын гудамж-711,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0311
Утас/Факс: 7011-8030 http://www.uscsofa.ub.gov.mn

2020.02.21 № 01/46

таний _____ -ны № _____ -г

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Тус газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын үр дүнтэй танилцлаа.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг цаашид дахин гаргахгүй байх талаар анхаарч ажиллах болно.

ГАЗРЫН ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

1150500041

4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	=	7 829 250.00
АВЛАГА	-	535 570.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	535 570.00
БАРАА МАТЕРИАЛ	-	7 293 680.00
Хангамжийн материал	-	7 293 680.00
Бичиг хэргийн материал	-	191 000.00
Аж ахуйн материал	-	5 808 460.00
Түлш, шатах тослох материал	-	290 000.00
Бусад хангамжийн материал	-	1 004 220.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	=	102 764 371.33
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	102 764 371.33
Биет хөрөнгө	-	98 612 704.65
Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	60 199 300.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(1 245 452.87)
Тавилга, аж ахуйн эд хогшил	-	39 957 100.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(298 242.48)
Биет бус хөрөнгө	-	4 151 666.68
Програм хангамж	-	1 430 000.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(238 333.32)
Бусад биет бус хөрөнгө	-	2 960 000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	=	110 593 621.33
НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	503 516.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	503 516.00
Өглөг	-	503 516.00
Ажилчидтай холбогдсон өглөг	-	503 516.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	=	110 090 105.33
Засгийн газрын хувь оролцоо	-	110 090 105.33
Хуримтлагдсан үр дүн	-	110 090 105.33
Тайлант үеийн үр дүн	-	110 090 105.33
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	=	110 593 621.33

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	481 570 000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	396 000.00
Нийтлэг татварын бус орлого	-	396 000.00
Бусад орлого	-	396 000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	481 174 000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33 888 000.00

**Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33 888 000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	447 286 000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	447 286 000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	371 479 894.67
УРСГАЛ ЗАРДАЛ	-	371 479 894.67
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	205 452 513.27
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	134 992 669.00
Үндсэн цалин	-	112 524 319.00
Нэмэгдэл	-	12 307 350.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	10 161 000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	16 874 084.00
Тэтгэврийн даатгал	-	13 481 210.00
Тэтгэмжийн даатгал	-	1 234 933.00
ҮОМШӨ-ний даатгал	-	935 262.00
Ажилгүйдлийн даатгал	-	169 175.00
Эрүүл мэндийн даатгал	-	1 053 504.00
Хангамж, бараа материалын зардал	-	14 147 231.60
Бичиг хэрэг	-	4 790 622.00
Тээвэр, шатахуун	-	6 363 163.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2 199 056.60
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	794 390.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	2 500.00
Багаж, техник, хэрэгсэл	-	2 500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	35 244 000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	35 244 000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	4 192 028.67
Бараа үйлчилгээний бусад зардал	-	1 210 000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1 200 000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	1 782 028.67
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	166 027 381.40
Бусад урсгал шилжүүлэг	-	4 924 270.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4 924 270.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	161 103 111.40
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	161 103 111.40
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	—	<u>110 090 105.33</u>
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	—	<u>110 090 105.33</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	481 570 000.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	396 000.00
Нийтлэг татварын бус орлого	-	396 000.00
Бусад орлого	-	396 000.00

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	481 174 000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33 888 000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33 888 000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	447 286 000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	447 286 000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	=	377 023 600.00
УРСГАЛ ЗАРДАЛ	-	377 023 600.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	210 996 218.60
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	135 204 880.00
Үндсэн цалин	-	135 204 880.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	16 693 927.00
Тэтгэврийн даатгал	-	15 701 937.00
Тэтгэмжийн даатгал	-	247 998.00
ҮОМШӨ-ний даатгал	-	198 398.00
Ажилгүйдлийн даатгал	-	49 599.00
Эрүүл мэндийн даатгал	-	495 995.00
Хангамж, бараа материалын зардал	-	15 240 251.60
Бичиг хэрэг	-	4 855 600.00
Тээвэр, шатахуун	-	6 653 163.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	2 731 578.60
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	999 910.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	2 587 700.00
Багаж, техник, хэрэгсэл	-	1 369 800.00
Тавилга	-	1 217 900.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	37 387 500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	37 387 500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3 881 960.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2 681 960.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1 200 000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	166 027 381.40
Бусад урсгал шилжүүлэг	-	4 924 270.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4 924 270.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	161 103 111.40
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	161 103 111.40
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	104 546 400.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	104 546 400.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	104 546 400.00
Дотоод эх үүсвэрээр	-	104 546 400.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	104 546 400.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(104 546 400.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	110 090 105.33	110 090 105.33
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	110 090 105.33	110 090 105.33

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	447,286,000.00	286,184,488.60	161,101,511.40	63.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	447,286,000.00	286,184,488.60	161,101,511.40	63.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,786,000.00	281,260,218.60	160,525,781.40	63.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,463,100.00	135,204,880.00	142,258,220.00	48.73
210101	Үндсэн цалин	205,973,900.00	135,204,880.00	70,769,020.00	65.64
210102	Нэмэгдэл	39,908,200.00	-	39,908,200.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,581,000.00	-	31,581,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,682,900.00	16,693,927.00	17,988,973.00	48.13
210201	Тэтгэврийн даатгал	23,584,400.00	15,701,937.00	7,882,463.00	66.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,774,600.00	247,998.00	2,526,602.00	8.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,219,700.00	198,398.00	2,021,302.00	8.94
210204	Ажилгүйдлийн даатгал	554,900.00	49,599.00	505,301.00	8.94
210205	Эрүүл мэндийн даатгал	5,549,300.00	495,995.00	5,053,305.00	8.94
2104	Хангамж, бараа материалын зардал	19,500,000.00	19,235,851.60	264,148.40	98.65
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	5,891,200.00	108,800.00	98.19
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	6,653,163.00	(1,653,163.00)	133.06
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,500,000.00	5,691,578.60	1,808,421.40	75.89

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	999,910.00	90.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,440,000.00	102,426,100.00	13,900.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,550,000.00	61,569,100.00	(19,100.00)	100.03
210602	Тавилга	40,890,000.00	40,857,000.00	33,000.00	99.92
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,500,000.00	3,499,500.00	500.00	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	3,499,500.00	500.00	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	4,199,960.00	40.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,999,960.00	(999,960.00)	150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,200,000.00	1,200,000.00	1,000,000.00	54.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,500,000.00	4,924,270.00	575,730.00	89.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,500,000.00	4,924,270.00	575,730.00	89.53
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00	4,924,270.00	575,730.00	89.53
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	447,286,000.00	447,286,000.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	447,286,000.00	447,286,000.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	447,286,000.00	447,286,000.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	24.00	8.00	75.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	21.00	8.00	72.41
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,888,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,888,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,888,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,888,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,888,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,888,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,888,000.00

Ажлын баримтын нэр:

Заглуулаагүй буруу шлэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл

Ажлын баримтын дугаар:

В501

Аудитын код:

НТАГ-2020/644/СТА-ТШЗ

мянган төгрөгөөр

Аудитын нэр:

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага с. гаргасан шийдэл	Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний		
									Албан тушаал	Овог нэр	
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	
Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал	1	1	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3."Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татаар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудыг зөрчсөн.		Зөвлөмж өгөх			Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх
Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал	2	1	Жилийн эцсийн тооллогын бүртгэлийн дүнг НББ-ийн програм, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулгахад ШТМ-ын талоны үлдэгдэлд тооллого хийгээгүй, тооцоо бодсоогүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." заалт, 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх беригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна." заалтуудыг зөрчсөн.	290.0	Зөвлөмж өгөх			Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх	
Зардлын данстай холбоотой асуудал	3	1	Эзлхийн амралтын олговор, цалинг давхардуулан илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно". Төсвийн тухай хуулийн 6.4.1."Төсвийг үр ашгатай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах." гэсэн заалтуудыг зөрчсөн.	851.0	Төлбөрийн акт тогтоох			Төлбөрийн акт тогтоох	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх	

4	Зардлын данстай холбоотой асуудал	1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар бүртгэл хөтлөж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнөг, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимгаар бичилт хийж баталгаажуулна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална. 5.1.4. Үнэн зөв байх; гэсэн заалтыг зөрчсөн.	2,486.0	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх
5	Зардлын данстай холбоотой асуудал	1	Тушаал шийдвэргүй, нотлох баримтгүй ажлагсдын гэр бүлийнхэнд бэлэг өгсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйцээг бүртгэхгүй байх; Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн	1,122.0	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх
6	Зардлын данстай холбоотой асуудал	1	Дуудлагаар автомашин унадаг албан тушаалтануудаас шалтгаалан илүү цагийн хөлс төлсөн, нэрийн хуудас хэвлүүлсэн зэрэг үрэлгэн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн	296.4	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх	
7	Зардлын данстай холбоотой асуудал	1	Шатахууны тооцооллыг давтан шалгахад илүү зарцуулсан (Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормоос илүү зарцуулсан/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйцээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх", 2006.11.27-ны өдрийн 388 тоот тушаалын 1 хавсралтын 3 бүлэг "Зардлыг хүлээн зөвшөөрөх ба үнэлэх" хэсгийн 3.2 дахь заалт "... гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн.	133.7	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх	
	Зардлын данстай холбоотой асуудал	1	АИ-95 төрлийн өртөг өндөргүй шатахуун авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; гэсэн заалтыг зөрчсөн.	60.0	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Төмөрдулам Б.Хэнмэдэх	
				5,239.1						

Танилцаж зөвшөөрсөн:
ХСОАБХЗГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч
С.Төмөрдулам
Огноо

Н.Баттоого
Огноо:
Д.Отгонбаяр
Огноо:
Ахлах нягтлан бодогч

НИЙТ ДҮН
2020.02.18
УХА/612.9077278

Бэлтгэсэн:
Аудитор
Анхан шатны хянасан:
Аудитын менежер
Хоёр дахь шатанд хянасан:

С.Төмөрдулам
Огноо
Б.Хэнмэдэх
Огноо

Ажлын

Аудитын явцад хийсэн зааруулгын тгавар

Ажлын баримтын дугаар:

530/03

Аудитын код:

НТГАГ-2020/644-СТА-ТШЗ

Мөнгөн төгрөгөөр

Аудитын нэр:

Хотын стандарт орчны ажлуугүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

№	Аудитын чиглэл	Тоо	Тухайн аудитын чиглэлд нөлөөлөх эрсдэлд хамаарах төлөвлөсөн горим сорилын үр дүнг (нөхцөл байдал) товч тодорхойлох	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Зааруулга хийх тайлан (мянган төгрөгөөр)																Зааруулга хийхэд үндэслэл болгосон стандарт, хууль, тогтоомжийн нэр, заалт	Нотлох зүйлсийн ишлэл (дугаар)	Тайл бар
					Санхүүгийн тайлан				Санхүүгийн тайлангийн тодруулга														
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21		
1		1	Үндсэн хөрөнгийн элэгдүүлэх жилийн 1 хугацааг их, бага хэмжээтэй тавьж бүртгэсэн														Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэгсэн байх.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 13.2. "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." заалт	Ажлын баримт			
2	Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт	1	Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар бүртгэхгүйгээр, шууд олгоон таллоноор зардалд бүртгэсэн	710.0							710.0						Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэгсэн байх.		Ажлын баримт			
3		1	Худалдан авсан бараа материалыг орлогод бүртгэлгүй шууд зардалд тайланасан	27,142.8							27,142.8						Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэгсэн байх.		Ажлын баримт			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn


2020.02.20 № 298
танай _____-ны № _____-т


ХОТЫН СТАНДАРТ ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 1,973.0 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг хүргүүлж байна.

Төлбөрийн актыг заасан хугацаанд барагдуулж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР



D:\Documents\Documents\2020 on\yvuusan bichig\2020.02.20.HSOAB.aktA5.docx

002030185



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 07/15

Улаанбаатар хот

НТАГ-2020/644/СТА - ТУЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан 851,000.0 /Найман зуун тавин нэгэн мянга/ төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг зөрчиж, аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг;
2. Тушаал шийдвэргүй, нотлох баримтгүй ажиллагсдын гэр бүлийнхэнд 1,122,000.0 /Нэг сая нэг зуун хорин хоёр мянга/ төгрөгийн бэлэг өгсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчиж, аудитын үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12. "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1. "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно", 3.1.7. "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан." заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зөрчлийн нийт 1,973,000.00 /Нэг сая есөн зуун далан гурван мянга/ төгрөгийг Нийслэлийн төрийн сан дахь НТАГ, хүү торгууль 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 5 дугаар сарын 25 -ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт

002050021

зохицуулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Төмөрдулам, нягтлан бодогч Б.Хэнмэдэх нарт хариуцуулав.¹

АКТ

ТОГТООСОН:


АХЛАХ АУДИТОР



Н.БАТТОГОО

ЗӨВШӨӨРСӨН:

**ХОТЫН СТАНДАРТ ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**



С.ТӨМӨРДУЛАМ


НЯГТЛАН БОДОГЧ



Б.ХЭНМЭДЭХ

ХЯНАСАН:

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН
АУДИТЫН МЕНЕЖЕР**



Д.ОТГОНБАЯР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР**



Ц.БАТ-ӨЛЗИЙ

¹ Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг Төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." гэж заасны дагуу албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.